



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2017 оны 01 сарын 23 өдөр

Дугаар А/35

Улаанбаатар хот


Эрх шилжүүлэх тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралт, Засгийн газрын 2016 оны 152 дугаар тогтоолын 3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн Сайдын багцаас 2017 онд төсвийн захирагч нарт эрх шилжүүлэн хэрэгжүүлэх Их засварын төсөл арга хэмжээний жагсаалтыг нэгдүгээр, Барилга байгууламжийн төсөл арга хэмжээний жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Хавсралтаар батлагдсан төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай" хуулийн дагуу зохион байгуулж, тайлагнах /гэрээ байгуулах, цуцлах, хяналт тавих, санхүүжүүлэх/-ыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай.

3. Худалдан авах ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Д.Очирбат/-д даалгасугай.



А.ЦОГЦЭЦЭГ

Эрүүл мэндийн сайдын 2017 оны 01 сарын 23-ны өдрийн 13 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



**ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРТ УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР 2017 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ИХ ЗАСВАРЫН ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭ**

/төгрөг/

№	Төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн нэр, хүчин чадал, байршил	Эхлэх хугацаа	Дуусах хугацаа	Төсөвт өртөг	2017 онд санхүүжих дүн
1	Эрүүл мэндийн төвийн барилгын их засвар ажлын дутуу санхүүжилт /Баянхонгор аймаг Галуут сум/	2017	2017	130,500,000	130,500,000

Эрүүл мэндийн сайдын 2017 оны 6-р сарын 25-ны өдрийн 1135 дугаар тушаалын хоёрдугаар хэвсрэлт



**МОНГОЛ УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР 2017 ОНД САНХҮҮЖҮҮЛЭХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ, БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЖАГСААЛТ**

/сая төгрөг/

Хуулийн дугаар	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг	Санхүүжих дүн
		Эхлэх	Дуусах		
XIII.1.11	Сумын эрүүл мэндийн төвийн барилга, 10 ор /Баянхонгор, Шаргалжуут сум/	2014	2018	1,112.7	200.0
XIII.1.12	Сумын эрүүл мэндийн төвийн барилга, 10 ор /Баянхонгор, Баянбулаг сум/	2014	2017	1,112.7	250.0